

**ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН
ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын даргын 2025 оны 252 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль тогтоомжийн нэр томъёоны тодорхойлолтын үг, хэллэгийг иргэд, олон нийт ойлгоход хялбар, энгийн, салаа утгагүй байдлаар илүү нарийвчлан томъёолж, хуульд хэрэглэгдэж буй “сорьц, хүйн эд, үндэсний хүлээх жагсаалт” зэрэг зарим нэр томъёоны тайлбарыг нэмж тусгалаа.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг нэмж тусгасан.

3.Эд, эсийг шилжүүлэн суулгах эмчилгээг илүү эрчимтэй хөгжүүлэх зорилгоор эсийн ангиллыг тусад нь зүйл болгож, олон улсад хэрэглэгдэж буй эмчилгээний шинэ технологи болох эд, эсийг хадгалах тусгай зориулалтын сан буюу био банкны зохицуулалтыг шинээр тусгалаа.

4.Амьд донорт тавигдах шаардлага, амьгүй донорыг илрүүлэх, бүртгэх асуудлыг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэн томъёолсон.

5.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Истанбулын тунхаглалын зарчмуудыг хуулийн төсөлд мөрдлөг болгож тусгасан.

6.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааг илүү оновчтой болгох хүрээнд шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоог нарийвчлан тодорхойллоо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хуулийн төслийн нэр, амьгүй донорын гэр бүлийн 3 гишүүнээс зөвшөөрөл авах талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай энэхүү харилцааг зохицуулж буй хүчин төгөлдөр эрх зүйн зохицуулалтын талаар болон донор хүлээж буй иргэдийн хувьд нөөцийн хуваарилалтыг хэрхэн шударга, хүртээмжтэй хийх талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар гэнэтийн тохиолдолд авах зөвшөөрлийг хэрхэн зохицуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир “амьгүй донор” гэсэн тодорхойлолт нь уламжлалт ёс заншилтай хэрхэн нийцэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр донор хүүхдийн насыг тогтоосон зохицуулалтыг хүүхдийн хүсэл зоригийг хүндэтгэн оновчтой тодорхойлох талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун эд, эс хадгалах био банкны өнөөгийн нөхцөл байдлын талаар, сургалт, судалгааны зохицуулалт бий эсэх, реципиент эмнэлгийн тоо, төлбөрийн урьдчилсан зохицуулалтын талаар, эсийн донорт тавих шаардлагад хүүхдийн насыг тогтоохдоо баримталсан эрх зүйн зохицуулалт нь хүүхдийн эрхийн зөрчил үүсгэсэн эсэх, зөвшөөрөл олгох гэр бүлийн гишүүдийн тоог ямар шалгуураар тогтоосон эсэх, амьгүй донорыг гэр бүлд нь хүлээлгэн өгөхдөө хүндэтгэлтэй хандах ёс зүйн хэм хэмжээ болон амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмжийн хэмжээний талаар, түүнчлэн тархины үхэл тодорхойлох мэргэшсэн баг болон эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Донорын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Л.ЭНХНАСАН

